Ус сувгийн удирдах газрын 2025 оны
11 дүгээр сарын 19-ны өдрийн
5/3272 тоот албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2025 ОНЫ АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр **Улаанбаатар хот**

"ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ, БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ"
01 ТООТ АЛБАН ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Хувь
1	1	"Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай"	Шинжлэх ухааны судалгаа нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонссон, итгэл хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах	Шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах зарчмыг хэрэгжүүлж, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний чанар, найдвартай байдлыг дээшлүүлэх чиглэлээр бодит арга хэмжээг авч ажиллаж байна. Иргэд, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг мэйлээр, утсаар, байгууллагын веб хуудсаар, eus.mn сайтаар дамжуулан авч, нийт хэрэглэгчдийн 10 хувийг судалгаанд хамруулсан санал хүсэлт, гомдол, шаардлагыг тогтмол хүлээн авч судлан, үйл ажиллагаандаа тусгаснаар нийтийн итгэлцэл, хүлээлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүллээ. Үүний үр дүнд хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдэж, байгууллагын ил тод, хариуцлагатай ажиллах соёл бэхэжсэн.	100
	2		Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах зарчмыг баримтлан, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, уялдаа холбоотой хэрэгжүүлж ажиллаж байна. Салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлж, баг хамт олныг үр дүнтэй удирдан чиглүүлэн, хариуцлагатай шийдвэр гаргах соёлыг төлөвшүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод, хариуцлагатай, шударга ёсны зарчимд тулгуурлан ажилласнаар байгууллагын нэр хүнд, олон нийтийн итгэлцэл нэмэгдэж байна. Ажилтнууд албан үүргээ гүйцэтгэх явцдаа	100

				байгуулагын хэмжээнд мөрдөж буй ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг чанд мөрдөн ажиллаж байна. Байгууллагын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг хангаж 10 удаагийн хяналт шалгалт хийж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГ-т хүсэлт гаргаж байгууллагын нийт ажилтнуудад ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулсан, шинээр батлагдсан хууль, дүрэм журмын суртчилгааг телеграмм, мэдээллийн самбар, сошиалд байршуулан мэдээллээр хангаж нийт ажилтнуудад танилцуулж ажилласан. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлж зохион байгуулалтын нэгжүүдэд тараах материал тарааж хууль сурталчилан ажилласан.	
	3		Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндержүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахих, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх	Газрын хэмжээнд сахилга, хариуцлага ажлын бүтээмжийг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлж, байгууллагын дотоод хяналт, ажлын хариуцлагыг өндөрсгөлөө. Төсвийн хэмнэлтийн горимыг чанд мөрдөж, үр ашиггүй зардлыг үе шаттайгаар танан, нөөцийг оновчтой зарцуулах арга хэмжээг хэрэгжүүлэн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үйл ажиллагааны давхардал, бүтэц зохион байгуулалтын зөрчилтэй чиг үүргийг дахин хянаж, орон тоог оновчтой түвшинд хүргэх зохицуулалтыг хийснээр байгууллагын үр ашиг, бүтээмж нэмэгдэж, төсвийн сахилга бат сайжирсан. 2025 онд зохион байгуулалтын бүтцээ шинэчилж, орон тооны дээд хязгаарыг 1943 байхаар батлуулан, 1758 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Ашиглалтад хүлээн аваагүй байгууламжууд болон ухаалаг ус түгээх байрны автоматжуулалттай холбоотойгоор нийт 156 орон тоо хэмнэгдсэн. Цаашид орон тоо, бүтцийг оновчтой болгож, төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан 2026 оны төлөвлөлтөө хэмнэлтийн чиглэлтэйгээр хэрэгжүүлнэ. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан 19 ажилтанг ажлаас халах, 35 ажилтанд сануулах болон 1-3 сарын хугацаанд үндсэн цалинг 30 хувь хүртэл бууруулах сахилгын	100

				арга хэмжээ, нийт 54 ажилтанд хариуцлага тооцсон бөгөөд дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг удидлагуудад үүрэг чиглэл болгож байна.	
	4		Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн иноваци шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан , их өгөгдлийг ашиглах	Байгууллагад бүтээмжийн менежер шинээр томилогдож байгууллагын стратеги, бизнес төлөвлөгөө шинэчлэн гаргахаар ажиллаж байна. Мянганы сорилтын сангийн санхүүжилтийн хүрээнд Монгол улсын хэмжээнд анх удаа гүний ус цэвэршүүлэх технологийн цогц байгууламжийг энэ ондоо багтаан ашиглалтанд оруулах, цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч байгаа усыг дахин боловсруулалт хийж ТЭЦ-3,4т техникийн усны зориулалтаар ашиглах үйлдвэрийг 2025 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Шинэ цэвэрлэх байгууламж болон Баруун эх үүсвэрийн сүлжээ бүрэн холбогдож, ажил эхлэхэд бэлэн болсон. Ус дахин боловсруулах төслийн шилэн кабель шинэ цэвэрлэх байгууламж руу татагдаж дуусаагүй, холболт хийгдээгүй хүлээгдэж байна. Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд дуудлагын нэгдсэн төвийн программ хангамжийг амжилттай нэвтрүүлж, 1800-1313 тусгай дугаарыг үйлчилгээнд ашиглаж эхэлсэн. Уг систем нь дуудлагыг хүлээн авч, хуваарилж, холбогдох зохион байгуулалтын нэгжүүдэд шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд мэдээлэл өгөх, санал хүсэлт, гомдол шийдвэрлэх процессыг цахимжуулсан.	100
	5		Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй шуурхай хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ажиц гаргаж, үр дүнг тайлагнах	Албан хаагч, инженер техникийн болон мэргэжлийн ажилтнуудын ажлын байранд тавигдах шаардлага хангахуйц нөөцийг бүрдүүлэх, байгууллага дотроо шатлан дэвших, дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэлт хийх зорилгоор 5 зохион байгуулалтын нэгжийн сул орон тоон дээр сонгон шалгаруулалтыг зарлаж, 35 ажил горилогчийг ажлын байраар хангасан.Нийт 66 нэр төрлийн өргөдөл ирсэн бөгөөд үүнээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл лавлагаа хүссэн өргөдөл 203 буюу нийт өргөдлийн 16.41 хувь, Нийгмийн халамж хүссэн өргөдөл 144 буюу нийт өргөдлийн 11.64 хувийг эзэлж байна. Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн талаар газрын шуурхайн зөвлөгөөнд 43 удаа танилцуулан НЗДТГ-т 7 хоногийн шийдвэрлэлтийн тайланг тогтмол илгээж байна. Тайлант хугацаанд 46 зөрчил гаргасан тул тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл	100

				цалингийн тохирох хувийг хасаж дахин зөрчил гаргахгүй байх талаар анхааруулан ажилласан.	
	6		Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу 44 шууд худалдан авалт болон 3 харьцуулалтын тендер, 29 нээлттэй тендер шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллаж байна. 1. Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/749 дугаар захирамжаар манай байгууллага нь Нэгдсэн Үндэстний байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламжийн Багц-3 "Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж ариутгах татуурга, усалгааны систем" хийх ажлыг гүйцэтгэхээр болсон. Ажлын хүрээнд 8 сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулсан. Тухайн ажлын ус хангамж, ариутгах татуургын хэсгийг гэрээний дагуу хийж гүйцэтгэж дуусан. 2. Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/1518 дугаар захирамжийн дагуу манай байгууллага нь "Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил гүйцэтгэх" НҮЦХ/2024-А/1518 дугаартай гэрээг байгуулан тухайн шугам сүлжээг угсрах ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тухайн ажлын хүрээнд 9 сонгон шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулан ажиллаж байна.	100
	7		Төрийн албаны нуцын тухай хуулийн дагуу нуцад хамааруулах шаардлаггүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн болон албаны нуцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагын нуцын журмыг шинэчилэн батлуулсан ба тагнуулын ерөнхий газраас санал авч албаны нуцад хамаарах 6-н төрлийн мэдээллийн жагсаалт гаргасан.	100
	8		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнг ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харья байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зүйл заалтын дагуу Ус сувгийн удирдах газрын Шил ажиллагааны нэгдсэн системд 10 дугаар сарын тайланг илгээж хянуулан баталгаажуулсан. 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 525 удаагийн мэдээлэл цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Техникийн нөхцөл олгох хурлын шийдвэр - 1, шилэн дансны мэдээлэл – 5 мэдээллүүдийг хуваарийн дагуу вэб хуудас	100

				дээр нийтэлж хэвшсэн. Байршуулаагүй болон хоцорсон мэдээлэл байхгүй.	
	9		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх	Байгууллагын дэргэд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нөлөөллийн аяныг зохион байгуулах удирдамж, хуваарийг батлан гаргаж, хуваарийн дагуу Бие биедээ анхаарал хандуулах өдрийг байгууллагын нийт зохион байгуулалтын нэгж бүрд зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фэйсбүүкт байршуулан ажилласан. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар баталгаажуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-ний хагас жилийн биелэлтийг гаргаж улирал тутам НЗДТГ-т тус тус хүргүүллээ. Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсээс 2025.05.15-ны 09.00 цагт цахимаар сургалтыг авч, сургалтанд байгууллагын бүх цэг салбар, зохион байгуулалтын нэгжүүдийн 155 ажилтан алба хаагч хамрагдсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тайлагнах, нуун дарагдуулахгүй байх, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах хариуцлага тооцох саналыг Газрын зөвлөлд оруулж шийдвэрлүүлж байна. Сургалт судалгааны төв дээр 3-6 дугаар саруудад ШУХА, ЗУХА-ны давхардсан тоогоор 800-аад ус түгээгч оператор, жолооч нарт эрх зүйн акт программыг таниулах, болон шинээр батлагдсан нэмэлт өөрчлөлт орсон хууль дүрэм журам, байгууллагын дотоод дүрэм журмын талаар мэдээлэл хүргэж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх сурталчлах ажил хийгдсэн. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан 19 ажилтанг ажлаас халах, 35 ажилтанд сануулах болон 1-3 сарын хугацаанд үндсэн цалинг 30 хувь хүртэл бууруулах сахилгын арга хэмжээ, нийт 54 ажилтанд хариуцлага тооцсон бөгөөд дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг удидлагуудад үүрэг чиглэл болгож байна.	100
	10		Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Ажилтан албан хаагчийн томилгоо, чөлөөлөлт болон хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн дарамт, шахалт, нөлөөлөл үзүүлэхгүйгээр шударга, ил тод	100

				зарчмаар ажиллаж байна. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/320 дугаар захирамжаар 26 зохион байгуулалтын нэгжтэй, 1943 орон тоотой батлуулан ажиллаж байна. Байгууллагын хүний нөөцийн эргэцийг 2024 оны мөн үетэй харьцуулан авч үзвэл зайлшгүй эргэлтийн коэффициент 0.08%, тогтворгүй байдлын коэффициент 0.27%, гаралтын коэффициент 0.53%, оролтын коэффициент 0.31% тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь өмнөх жилээс тогтвор суурьшил сайжирсан харагдаж байна. Албан хаагч, инженер техникийн сул ажлын байранд тавигдах шаардлага хангахуйц нөөцийг бүрдүүлэх, байгууллага дотроо шатлан дэвшүүлэх бодлогыг барьж ажиллан нийт 11 ажилтныг албан тушаал дэвшүүлэн ажиллуулсан.	
	11		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага хуулийн этгээдийн удирдлагад өгч, үр дүнг тооцож ажиллах	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын орлого нэмэгдүүлж, алдагдал бууруулах ажлын төлөвлөгөөг 4 чиглэл, 13 хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулж, Газрын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-05 дугаар сарын үйл ажиллагааны зардлын төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тооцоо, орлогын мэдээг сар бүрийн 07-ний өдрийн дотор газрын шилэн данс, веб сайт, мэдээллийн самбарт байршуулсан.Мөн байгууллагын 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, аудитын зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр шилэн данс, веб сайтад байршуулсан.	100
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 02 ДУГААР АЛБАН ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ					
Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Хувь
1	1	Нийгмийн шударга ёсыг	1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийгн хэрэгжилтийг эрчимжүүлэн, авилга албан тушаалын	Байгууллагын үйл ажиллагааны болон Зохион байгуулалтын нэгжүүдийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Авлигын эсрэг болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,	100

		хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай	гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцлийг арилгах талаар авах цогц арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх	соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар нийт 6 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай байна. Мөн нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний хагас жилийн биелэлтийг гаргаж 2025.06.17-ны өдрийн 07/1911 албан бичгээр НЗДТГ-т тус тус хүргүүллээ.	
	2		1.2. Авилга албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг ашиглан шамшигдуулсан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон хөрөнгийг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж санал боловсруулан 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх	Тус байгууллагад уг заалт хамааралгүй болно. Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн 2025.06.06-ны өдрийн 04/10817 тоот зөвлөмж , саналын дагуу "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр төлбөрт ажил, үйлчилгээ үзүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ИТА, албан хаагчдыг авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тодорхой заалтуудыг журмын төсөлд оруулсан болно.	100

"ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ"
03 ДУГААР АЛБАН ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Хувь
1	1	Төр, засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй, тогтвортой байх зарчмыг хангаж ажиллах	1.1.Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх	Албан хаагч, инженер техникийн болон мэргэжлийн ажилтнуудын ажлын байранд тавигдах шаардлага хангахуйц нөөцийг бүрдүүлэх, байгууллага дотроо шатлан дэвших, дотоод болон гадаад нөөцөөс бүрдүүлэлт хийх зорилгоор 5 зохион байгуулалтын нэгжийн сул орон тоон дээр сонгон шалгаруулалтыг зарлаж, 35 ажил горилогчийг ажлын байраар хангасан. Нийт 66 нэр төрлийн өргөдөл ирсэн бөгөөд үүнээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл лавлагаа хүссэн өргөдөл 203	100

				буюу нийт өргөдлийн 16.41 хувь, Нийгмийн халамж хүссэн өргөдөл 144 буюу нийт өргөдлийн 11.64 хувийг эзэлж байна. Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн талаар газрын шуурхайн зөвлөгөөнд 43 удаа танилцуулан НЗДТГ-т 7 хоногийн шийдвэрлэлтийн тайланг тогтмол илгээж байна. Тайлант хугацаанд 46 зөрчил гаргасан тул тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл цалингийн тохирох хувийг хасаж дахин зөрчил гаргахгүй байх талаар анхааруулан ажилласан.	
	2		1.2.Харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан 19 ажилтанг ажлаас халах, 35 ажилтанд сануулах болон 1-3 сарын хугацаанд үндсэн цалинг 30 хувь хүртэл бууруулах сахилгын арга хэмжээ, нийт 54 ажилтанд хариуцлага тооцсон бөгөөд дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг удидлагуудад үүрэг чиглэл болгож байна.	100
	3		1.3.Зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу 44 шууд худалдан авалт болон 3 харьцуулалтын тендер, 29 нээлттэй тендер шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллаж байна. 1. Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/749 дугаар захирамжаар манай байгууллага нь Нэгдсэн Үндэстний байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламжийн Багц-3 “Гадна инженерийн шугам сүлжээний ажил, ус хангамж ариутгах татуурга, усалгааны систем” хийх ажлыг гүйцэтгэхээр болсон. Ажлын хүрээнд 8 сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулсан. Тухайн ажлын ус хангамж, ариутгах татуургын хэсгийг гэрээний дагуу хийж гүйцэтгэж дуусан. 2. Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/1518 дугаар захирамжийн дагуу манай байгууллага нь “Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил гүйцэтгэх” НҮЦХ/2024-А/1518 дугаартай гэрээг байгуулан тухайн шугам сүлжээг	100

				угсрах ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тухайн ажлын хүрээнд 9 сонгон шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулан ажиллаж байна.	
	4		1.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Байгууллагын дэргэд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025.05.15-ны 09.00 цагт Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсээс цахимаар сургалтыг авч, сургалтанд байгууллагын бүх цэг салбар, зохион байгуулалтын нэгжүүдийн 155 ажилтан алба хаагч хамрагдсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тайлагнах, нуун дарагдуулахгүй байх, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах хариуцлага тооцох саналыг Газрын зөвлөлд оруулж шийдвэрлүүлж байна. Мөн төрийн албан хаагчийн ёс, зүй, авилга, ашиг сонирхлын талаарх анхааруулга, санамж постерыг байгууллагын цахим хаягт байршуулан албан хаагч, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.	100
	5		1.5.Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/320 дугаар захирамжаар 26 зохион байгуулалтын нэгжтэй, 1943 орон тоотой батлуулан ажиллаж байна. Хагас жилийн байдлаар байгууллагын хүний нөөцийн эргэцийг 2024 оны мөн үетэй харьцуулан авч үзвэл зайлшгүй эргэлтийн коэффициент 0.08%, тогтворгүй байдлын коэффициент 0.27%, гаралтын коэффициент 0.53%, оролтын коэффициент 0.31% тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь өмнөх жилээс тогтвор суурьшил сайжирсан харагдаж байна. Албан хаагч, инженер техникийн сул ажлын байранд тавигдах шаардлага хангахуйц нөөцийг бүрдүүлэх, байгууллага дотроо шатлан дэвшүүлэх бодлогыг барьж ажиллан нийт 11 ажилтныг албан тушаал дэвшүүлэн ажиллуулсан.	100
	6		1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын орлого нэмэгдүүлж, алдагдал бууруулах ажлын төлөвлөгөөг 4 чиглэл, 13 хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулж, Газрын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-05 дугаар сарын үйл ажиллагааны зардлын төсвийн	100

			этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	хэтрэлт, хэмнэлтийн тооцоо, орлогын мэдээг сар бүрийн 07-ний өдрийн дотор газрын шилэн данс, веб сайт, мэдээллийн самбарт байршуулсан. Мөн байгууллагын 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, аудитын зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр шилэн данс, веб сайтад байршуулсан.	
2	1	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр	2.1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцалд хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох	Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Байгууллагын нууцын журмыг шинэчилэн батлуулсан. Тагнуулын ерөнхий газраас санал авч албаны нууцад хамаарах 6-н төрлийн мэдээллийн жагсаалт гаргасан.	100
	2		2.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зүйл заалтын дагуу Ус сувгийн удирдах газрын Шил ажиллагааны нэгдсэн системд 10 дугаар сарын тайланг илгээж хянуулан баталгаажуулсан. 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 525 удаагийн мэдээлэл цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Техникийн нөхцөл олгох хурлын шийдвэр - 1, шилэн дансны мэдээлэл – 5 мэдээллүүдийг хуваарийн дагуу вэб хуудас дээр нийтэлж хэвшсэн.	100
	3		2.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх. бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	Байгууллагын дэргэд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025.05.15-ны 09.00 цагт Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсээс цахимаар сургалтыг авч, сургалтанд байгууллагын бүх цэг салбар, зохион байгуулалтын нэгжүүдийн 155 ажилтан алба хаагч хамрагдсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тайлагнах, нуун дарагдуулахгүй байх, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах хариуцлага тооцох саналыг Газрын зөвлөлд оруулж шийдвэрлүүлж байна. Сургалт судалгааны төв дээр 3-6 дугаар саруудад давхардсан тоогоор 800-аад ус түгээгч оператор, жолооч нарт эрх зүйн акт программыг таниулах, болон шинээр батлагдсан нэмэлт өөрчлөлт орсон хууль дүрэм журам, байгууллагын дотоод дүрэм журмын талаар мэдээлэл хүргэж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэх,	100

				соён гэгээрүүлэх сурталчлах ажил хийгдсэн. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, хөдөлмөрийн гэрээний үүргээ биелүүлээгүй хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан 19 ажилтанг ажлаас халах, 35 ажилтанд сануулах болон 1-3 сарын хугацаанд үндсэн цалинг 30 хувь хүртэл бууруулах сахилгын арга хэмжээ, нийт 54 ажилтанд хариуцлага тооцсон бөгөөд дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг удидлагуудад үүрэг чиглэл болгож байна.	
3	1	Өвөлжилтийн бэлтгэлийг хангах, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой асуудлаар	3.3.Аймгийн төв, хүн ам төвлөрсөн томоохон сум, суурин газрын иргэдийн орон сууц, төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг цахилгаан, эрчим хүч, дулаан, усаар найдвартай хангах, иргэдийг ая, тухтай өвөлжүүлэх. 2025-2026 оны өвөлжилтийн үеэр гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангахаар шугам сүлжээтэй холбоотой 11 ажил, барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэл, засвартай холбоотой 5 ажил, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээтэй холбоотой 10 ажил, цэвэр усны хаалт, галын гидрант солих 90 ажил, цахилгаан хангамжтай холбоотой 107, бусад 1 ажил нийт 224 ажил төлөвлөснөөс 100 хувийн биелэлттэй 209 ажил, 90 хувийн биелэлттэй 1 ажил, тендер амжилтгүй болсон 14 ажил байна. Төлөвлөгөөний биелэлт 93.7 хувьтай байна.	100

“ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
04 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Хувь
1	1	2025-07-25 Дугаар 2025_04	1.2. Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн	Зохион байгуулалтын бүтцээ 2025 онд шинэчилж, орон тооны дээд хязгаарыг 1943 байхаар батлуулсан. Чиг үүргийн давхардал арилгах зорилгоор газрын даргын 06 дугаар сарын 16-ны өдрийн А/168 дугаар тушаалаар 422 ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж баталгаажуулсан. Мөн тайлант хугацаанд 29 сул орон тоог царцааж нөхөн томилгоо хийхгүй ажилласан.	100

			Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;		
	2		1.3. Иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	Байгууллагын нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр сургалт зохион байгуулж, хуулийн гол заалтуудыг танилцуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нөлөөллийн аяныг зохион байгуулах удирдамж, хуваарийг батлан гаргаж, хуваарийн дагуу Бие биедээ анхаарал хандуулах өдрийг байгууллагын нийт зохион байгуулалтын нэгж бүрд зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фэйсбүүкт байршуулан ажилласан.	100
	3		1.4. Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Байгууллагын дэргэд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нөлөөллийн аяныг зохион байгуулах удирдамж, хуваарийг батлан гаргаж, хуваарийн дагуу Бие биедээ анхаарал хандуулах өдрийг байгууллагын нийт зохион байгуулалтын нэгж бүрд зохион байгуулж, тайлан, мэдээллийг байгууллагын дотоод фэйсбүүкт байршуулан ажилласан.	100
	4		1.7. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн болов албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр	Манай байгууллага нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасан "төрийн жинхэнэ албан хаагч" болон "төрийн үйлчилгээний албан хаагч"-ийн ангилалд хамаарахгүй. Иймд тухайн хуульд тусгагдсан төрийн албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаалын тодорхойлолт өөрчлөхтэй холбоотой зохицуулалт нь манай байгууллагын үйл ажиллагаанд шууд хамаарахгүй болно. Манай байгууллагын ажилтнууд нь хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журам, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцаа зохицуулагддаг тул дээрхи заалтын биелэлт нь манай байгууллагад хамааралгүй гэж үзэж байна.	-

			гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;		
	5		1.8. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Манай байгууллага нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бөгөөд Төрийн албаны тухай хуульд заасан “төрийн албан хаагчийн” ангилалд хамаарахгүй хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг байгууллага юм. Иймд төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулахтай холбоотой тус заалтын биелэлт нь манай байгууллагад шууд хамаарахгүй болно.	-

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЧИРБАТ